



**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 30

Өмнөдэлгэр сум

**2026 онд ойгоос бэлтгэх модны
дээд хязгаар батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.3, 32.3.1, 32.3.2, 32.3.3 дахь заалтууд, аймгийн ИТХурлын 2024 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Наймдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Сумын ойн сангаас 2026 онд мод бэлтгэх ойн мэргэжлийн байгууллагын модны дээд хязгаарыг огтлолт, модны төрлөөр 1 дүгээр хавсралтаар, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нөхөрлөл болон багийн ахуйн хэрэгцээний модны дээд хязгаарыг модны төрлөөр 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж бэлтгэсэн модныхоо 100 м³ тутамд 2.0 га-д, арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бэлтгэсэн модныхоо 100 м³ тутамд 1.0 га-д, ойн цэвэрлэгээний ажлаар ойгоос мод бэлтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага бэлтгэсэн хэрэглээний модныхоо 100 м³ тутамд 0.5 га-д өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, тайланг хагас, бүтэн жилээр Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр), Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга (Б.Давхарбаяр) нарт даалгасугай.

3. Ойн мэргэжлийн байгууллагат хуваарилсан нийт модны хуваарийн 30%-ийг сумын иргэдийн ахуйн хэрэглээний байшин, малын хашаа, саравч барих, түлшний модны хэрэгцээнд зарцуулахыг мод бэлтгэх эрх авсан тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн захирал нарт даалгасугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороонд үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ПҮРӨВДОРЖ



Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12-р сарын 17-ны өдрийн ээлжит наймдугаар хуралдааны 30. Дугаар тогтоолын 1 дүгээр хэсгээр

2026 онд Өмнөдэлгэр сумын ойн сангаас ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэх дээд хязгаар /огтлолтын төрөл болон модны төрлөөр/

№	Ойн мэргэжлийн байгууллагын нэр	Модны төрөл	Огтлолтын төрөл																Нийт өөрийн хөрөнгийн ойжуулалт /га/						
			Үйдвэрлэлийн ашиглалтын огтлолтоор				Арчилгааны огтлолтоор				Цэвэрлэгээний огтлолтоор				Цэвэрлэгээний ажлаар					Бүгд дүн /м3/					
			Харгалз /м3/	Түлээ /м3/	Бүгд /м3/	Өөрийн хөрөнгийн	Харгалз /м3/	Түлээ /м3/	Бүгд /м3/	Өөрийн хөрөнгийн	Харгалз /м3/	Түлээ /м3/	Бүгд /м3/	Өөрийн хөрөнгийн	Харгалз /м3/	Түлээ /м3/	Бүгд /м3/	Өөрийн хөрөнгийн			га				
1	Модон цаг ХХК	Шинэс	250	75	325	6.5	22	50	16	66	0.66	4	330	500	830	8.3	42	80	120	200	0.4	10	1421	15.9	
		Дүн	250	75	325	6.5	22	50	16	66	0.66	4	330	500	830	8.3	42	80	120	200	0.4	10	1421		
2	Зоос булаг ХХК	Шинэс	230	69	299	6.0	20	50	16	66	0.66	4	340	500	840	8.4	42	80	120	200	0.4	10	1405	15.4	
		Дүн	230	69	299	6.0	20	50	16	66	0.66	4	340	500	840	8.4	42	80	120	200	0.4	10	1405		
3	Их баян дуурлиг ХХК	Шинэс	160	48	208	4.2	14	50	16	66	0.66	4	330	500	830	8.3	42							1104	13.4
		Хус						21	7	28	0.28													28	
4	Ган соёмбо ХХК	Шинэс	160	48	208	4.2	14	71	23	94	0.94	4	330	500	830	8.3	42							1132	8.3
		Дүн	160	48	208	4.2	14	71	23	94	0.94	4	330	500	830	8.3	42							1132	
5	Өлзийт бүтээмж ХХК	Шинэс	100	30	130	2.6	9	30	11	41	0.41	3	200	300	500	5.0	25	60	90	150	150	0.3	7.5	821	8.3
		Дүн	100	30	130	2.6	9	30	11	41	0.41	3	200	300	500	5.0	25	60	90	150	150	0.3	7.5	821	
Нийт дүн			840	252	1092	21.8	73	231	77	308	3.08	19	1400	2100	3500	35	175	280	420	700	1.4	35.0	5600	61.3	

Өмнөдэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2016 оны 11-р сарын 17-ны өдрийн
ээлжит Наймдугаар хуралдааны 30 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

2026 онд Өмнөдэлгэр сумын ойн сангаас уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
ойн нөхөрлөлүүд болон багийн ахуйн хэрэгцээний мод бэлтгэх дээд хязгаар
/огтлолын төрөл шоометр/

№	Нөхөрлөл болон багийн нэр	Модны төрөл	Цэвэрлэгээний ажил м3				Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор м3		
			Хэрэглээ	Түлээ	Бүгд	га	Хэрэглээ	Түлээ	Бүгд
1	Лаглуу нөхөрлөл	шинэс		40	40	2			
2	Баруун жаргалант нөхөрлөл	шинэс	10	40	50	2			
3	Баян өлзийт нөхөрлөл	шинэс	20	60	80	3			
4	Өгөөмөр нөхөрлөл	шинэс	30	70	100	4			
5	Мангирт нөхөрлөл	шинэс	50	100	150	6			
6	Чандмань нөхөрлөл	шинэс	20	50	70	3			
7	Нөөлөгт	шинэс	10	40	50	2			
8	Наран баг	шинэс	50	400	450				
9	Баян зүрх баг	шинэс	100	500	600		30	10	40
		нарс					20	10	30
		хуш					20	10	30
10	Хэнтий баг	шинэс	110	600	710		30	10	40
11	Талын булаг баг	шинэс		100	100				
		улиас	50	60	110				
12	Чандган баг	шинэс		140	140				
13	Төвийн баг	шинэс	50	500	550				
14	Гурван баян тосгон	шинэс	100	700	800				
	Нийт		600	3400	4000	22	100	40	140